



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/383

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 40 дүгээр хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2020 оны 28 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 06.00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 06.00 цаг хүртэл сунгасугай.

Хоёр. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг баар, цэнгээний газар, караоке, бариа массаж, фитнес, саун, цахим тоглоом, хичээл сургалт, семинар, цугларалт, хэлэлцүүлэг, курс дамжаа, секц, дугуйлан, үзвэр, спорт заал, уралдаан тэмцээн болон олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 06.00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд хориглосугай.

Гурав. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдэд 18 градусаас доош спиртийн агууламжтай согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг 12 дугаар сарын 31-ний өдрөөс зөвшөөрсүгэй.

Дөрөв. Хөл хорио тогтоосон хууль тогтоомжийг мөрдөж, онцын шаардлагагүй бол гэрээсээ гарахгүй байж, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжийг хэрэгжүүлэн, халдвар, хамгааллын дэглэмийг баримтлахыг аймгийн нийт иргэдэд уриалсугай.

Тав. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр хязгаарлаж, дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлэхээр зохицуулсугай.

482011152

Зургаа. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасантай холбогдуулан 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа иргэдийн PCR шинжилгээг сайтар нягтлан 48 цаг өнгөрсөн, шинжилгээний хариу www.119.mn, eruul.gerege.mn цахим сайтад хүлээлгийн горимд байгаа гэсэн өгүүлэмжтэй иргэдийг нэвтрүүлэхгүй байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Долоо. Голомтын бүс нутгаас ирж гэрийн ажиглалтад байгаа иргэд, ар гэрийнхэнд тавих хяналтыг сайжруулж, мэдээ, мэдээлэл, заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

Найм. Төрийн байгууллагуудыг ажлын тусгай горимоор ажиллуулах цагийн хуваарийг баталж мөрдүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

Ес. Захирамжийг хэрэгжүүлж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр нь танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ